

14. ЗӨГИЙН БАЛНЫ НИЙЛҮҮЛЭЛТ



14-1. Тогтвортой нийлүүлэлт хамгийн чухал	231
14-2. Хэрэглэгчдийн итгэлийг хүлээх	233

Монгол орон нь өргөн уудам газар нутагтай, хүн ам харьцангуй цөөхөн онцлог бүхий орон юм. Мөн хүн амын тал хувь нь нийслэл Улаанбаатар хотод амьдардаг нь бас нэгэн онцлог гэж хэлж болно. Зөгийн аж ахуй эрхлэгчдийн хувьд эх орныхоо зах хязгаарт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ хүн амын ихэнх нь амьдарч байгаа Улаанбаатар хотын хэрэглэгчдэд хэрхэн борлуулах, мөн бусад орон нутагт хэрхэн хүргэх вэ гэдэг нь бэрхшээлтэй байдаг. Ингээд зөгийн балны нийлүүлэлтийн талаар авч үзье.

14-1. Тогтвортой нийлүүлэлт хамгийн чухал

Өнөөг хүртэл ихэнх зөгийчид зөгийн балаа хэрэглэгчдэд шууд борлуулдаг байсан. Зөгийчид зөгийн балны гол зах зээл болох Улаанбаатар хотыг зорьж намрын үзэсгэлэн худалдаагаар дамжуулан хэрэглэгчдэд шууд борлуулдаг. Эсвэл зах, жижиг дэлгүүрүүд болон ченж гэх зэрэг хэрэглэгчдэд ойр байдаг дэлгүүрүүдэд зардаг зөгийчид ч бий.

Жижиг аж ахуйн 10, 15 бүл зөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт ихэнхдээ тогтворгүй байдалтай байх нь олонтаа байдаг. Зөгийн балны амт, өнгө үнэрийг онцгойлон анхаарч бүтээгдэхүүнээ төрөлжүүлж үйлдвэрлэх аж ахуй цөөхөн бөгөөд бүтээгдэхүүнээ бэлэн болмогц тэр дор нь зардаг төрлийн зөгийчид олон байна. Иймд зөгийн балны үйлдвэр нь зөгийчдөөс баталгаатай зөгийн балыг худалдан авч стандартыг мөрдөж ажиллах төдийгүй өнгө, амт зэрэг чанар нь жигд байх зөгийн балыг ихээр бэлтгэх шаардлагатай.


Зураг 14-1а. Улаанбаатар хотын хэрэглэгчдийн зөгийн бал худалдан авдаг дэлгүүр (2021 онд хэрэгжүүлсэн судалгаа)



Эх сурвалж: ЗӨГИЙН БАЛНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА (MONMAP-AVC)

Нөгөө талаар сүүлийн үед супермаркетаас зөгийн бал худалдаж авдаг хэрэглэгчид нэмэгдэж байна (Зураг 14-1a). Хэрэглэгчийн хувьд “амттай” гэж бодсон зүйлээ “идэхийг хүссэн” үедээ хэдийд ч байсан худалдаж авах боломжтой байх нь нэн чухал юм. Харин супермаркетууд үйлчлүүлэгчдийн “худалдаж авмаар байгаа” зүйлээ “хүссэн үедээ худалдаж авах” боломжийг бүрдүүлж борлуулалт хийдэг байх нь хамгийн чухал. Ижил чанартай бүтээгдэхүүн байнга худалдаалах нөхцлийг хангахын тулд тогтвортой нийлүүлэлтийг шаарддаг. Супермаркетын зүгээс шаардах чанартай зөгийн балыг супермаркетад байнга нийлүүлэхийг жижиг зөгийн аж ахуй эрхлэгчид тус тусдаа хэрэгжүүлэхэд хүндрэлтэй юм.

Дотоодын зөгийн балны үйлдвэрлэлийн хэмжээ өсч байгаа хэдий ч импортын зөгийн бал их хэвээр байна. Өнөөдөр Монголд нэг хүн жилд 130 грамм зөгийн бал идэж байна Үүнийг Монгол улсын 3 сая 300 хүнд харьцуулахад жилд нийт 420 тн зөгийн бал хангалттай гэсэн тооцоо гарч байна. Гэвч дотоодын зөгийн бал үйлдвэрлэлийн хэмжээ 2019 онд 221 тн, импортлосон зөгийн балны хэмжээ 289 тн, дотоодын зах зээл дээрх зөгийн бал нийт 510 тн болж байна. Илүүдэл 90 тн зөгийн бал зарагдаагүй зооринд, зөгийчдийн агуулахад, зөгийн балны үйлдвэрийн агуулах зэрэгт үлдсэн гэсэн үг юм.



Иймээс зөгийн аж ахуй эрхлэгчид болон зөгийн балны үйлвэрүүдэд зах зээлээ өргөжүүлэх явдал чухал асуудлын нэг билээ. Зах зээлийн хүрээ дотоодоор хязгаарлагдахгүй. Гадаад зах зээлийг ч гэсэн зорьж ажиллах хэрэгтэй. Монгол улсын Засгийн газраас зөгийн балны экспортыг эхлүүлэхээр зорьж байна. Гэвч экспортлох тохиолдолд “Чанар”, “Хэмжээ”-г дотоодын зах зээлээс илүүтэйг шаардах болно. Экспортлох тохиолдолд ялангуяа жижиг аж ахуй эрхлэгчдийн хувьд ганц ганцаараа борлуулдаг байх биш жигд чанартай зөгийн балыг их хэмжээгээр үйлдвэрлэдэг болох мөн зөгийн балны үйлдвэр нэгтгэн авч тогтвортой нийлүүлэх шаардлага бий болно (Зураг 14-1c).

Зураг 14-1с. Зөгийн балны нийлүүлэлт




Эх сурвалж : MONMAP-AVC

14-2. Хэрэглэгчдийн итгэлийг хүлээх

Импортын зөгийн балтай өрсөлдөх зах зээлд ялахын тулд хэрэглэгчдийн хүсэлд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж борлуулах шаардлагатай. Хэрэглэгчид “дотоодын бүтээгдэхүүн байх”, “амттай байх”, “үйлдвэрлэлийн явцыг мэдэх боломжтой байх”, “цэвэрхэн байх” бүтээгдэхүүнийг авахыг хүсдэг (Зураг 14-2). Гадаадын хэрэглэгчид ч мөн зориуд Монгол орноос зөгийн бал импортлож байгаа бол яг Монголд үйлдвэрлэсэн, аюулгүй, амттай зөгийн бал авч идэхийг хүсэх нь ойлгомжтой.

Зураг 14-2. Зөгийн балны хэрэглээнд хийсэн судалгаа



Эх сурвалж: 2019 онд хэрэгжүүлсэн BeeDep-MONGOL2 төслийн судалгаа

Зөгийн бал бол хуурамч бүтээгдэхүүн ихтэй хүнсний бүтээгдэхүүний нэг юм. Зөгийн баланд элсэн чихэр хольсон сахарын уусмалыг зөгийн бал хэмээн хийсэн хуурамч бүтээгдэхүүн, балт ургамлыг худлаа хэлэх, үйлдвэрлэсэн газар, орон нутгийг худлаа хэлэх зэрэг олон хуурамч зөгийн бал гаргадаг. Жинхэнэ зөгийн бал биш атал зөгийн бал гэж борлуулах, Орос зөгийн балыг Монгол зөгийн бал хэмээн зарах нь хууль зөрчсөн үйлдэл бөгөөд энэ нь луйвар юм.

Хэрэглэгч болон импортлогч компаниуд зөгийчид болон зөгийн балны үйлдвэрт итгэж худалдан авалт хийхийг хүснэ. Энэ итгэлийг алдах нь Монгол зөгийн аж ахуйн хөгжилд саад болох нэг хүчин зүйл болно.

Тийм учраас чинхүү сэтгэл зүрхтэй зөгийчин та жинхэнэ зөгийн бал болоод аюулгүй, чанартай сайн зөгийн бал, худал түүхгүй зөгийн бал үйлдвэрлэхийн тулд MNS чанд мөрдөн, малын эмчтэй гэрээ хийж зөгийн балны эргэн мөшгих системд мэдээллээ оруулж байх хэрэгтэй.

Зөгийн балны үйлдвэр зөгийчдөөс худалдаж авсан зөгийн балны аюулгүй савлагааг баталж HACCP болон ISO9001 зэрэг гэрчилгээ авч бүтээгдэхүүний бүх цувралыг лабораториар шинжлүүлж аюулгүй байдлыг баталгаажуулах ба хэрэглэгчдэд үйлдвэрлэлийн явцын түүхийг харуулахын тулд эргэн мөшгих системд мэдээллээ оруулна.

Хэрэглэгчийн итгэлийг хүлээхийн тулд зөгийн бал нийлүүлэх бүхий л үе шатанд аюулгүй байдал, стандартыг мөрдөн ажиллах шаардлагатай бөгөөд зөгийчид болон зөгийн балны үйлдвэрийн аюулгүй байдал, стандартыг мөрдөж ажиллаж байгаа үйл ажиллагааг хэрэглэгчдэд ил тод, ойлгомжтой байх нь туйлын чухал.